



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/503

Мандалговь

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Захиргааны ерөнхий хуулийн 60, 61, 62 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Бичил уурхайгаар олборлосон ашигт малтмал худалдан авах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах журам боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Түвшинбаяр (Хууль эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүд: Н.Эрдэнэ-Очир (ХОХБТХ-ийн дарга)

Р.Цэрэндорж (МХГ-ын Геологи уул уурхайн хяналтын улсын байцаагч)

Х.Анхбаяр (БОАЖГ-ын ахлах мэргэжилтэн)

Т.Уранбайгаль (Хууль эрхзүйн хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: П.Очирбат (ХОХБТХ-ийн мэргэжилтэн)

Хоёр. Бичил уурхайгаар олборлосон ашигт малтмал худалдан авах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах журмын төслийг 11 дүгээр сарын 23-ны өдрийн дотор боловсруулан, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхийг ажлын хэсэг (Б.Түвшинбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж.МӨНХЧУЛУУН

438010540